

2019 он 02 сар 19 өдөр

Дугаар 2119

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 76 дугаар зүйлийн 76.1.12, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 сарын 18-ны өдрийн хурлыг шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 50% (тавин хувь)-иар тооцож, нэгж хувьцаанд 25.27 (хорин таван төгрөг хорин долоон мөнгө) төгрөг, нийт 631,701,747.92 (зургаан зуун гучин нэгэн сая долоон зуун нэгэн мянга долоон зуун дөчин долоон төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй байгуулсан гэрээний үндсэн дээр 2019 оны 6 сарын 29-ний өдрийн дотор хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захирал (Г.Цогбадрах)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.ГАНХУЯГ

2019 он 2 сар 18 өдөр

Дугаар 3/16

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2019 оны 4 сарын 27-ны өдрийн 9:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2019 оны 2 сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2019 оны 2 сарын 25-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2019 оны 3 сарын 12-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2019 оны 3 сарын 4-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

6. Хурлын даргаар Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг томилсугай.
7. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга Э.Гэрэлчимэг

Хуулийн зөвлөх Ж.Дамбаасүрэн

Ахлах шинжээч Г.Баярбат

Маркетингийн менежер Н.Хандмаа.

8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Г.Цогбадрах/-т даалгасугай.
10. Хурлын Тооллогын комиссоор Г.Алтансүх (Блүмсбюри ҮЦК ХХК)-ийг сонгон ажиллуулсугай.

ДАРГА:



Ч.ГАНХУЯГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 2 сарын 18-ны өдрийн
..тоот тогтоолын Хавсралт №1

**2019 ОНЫ 4 САРЫН 27-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСЛААЛТ**

1. 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 2 дугаар сар 18-ны өдрийн
..тоот тогтоолын Хавсралт №2

**АРД ДААТГАЛ ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 4 сарын 27-ний өдрийн 9:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай;	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Ард Секюритиз Үнэт цаасны компани (ҮЦК)-д ирж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____
Санал авах хуудсыг үйлдсэн 2019 оны .. сарын .. өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй
Тооллогын комиссын дарга _____ /...../
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 2 сарын 18-ны өдрийн
..тоот тогтоолын Хавсралт №2

**АРД ДААТГАЛ ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2019 оны 4 сарын 27-ний өдрийн 9:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүд		
1		
2		
3		
4		
5		
6		
7		
Хараат бус гишүүд		
1		
2		
3		
4		

Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны

тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй ($100 \times 9 \text{ гишүүн} = 900$) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч нь лунь лүн били нингийн хуудна дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____/...../

Санал авах хуудсыг үйлдсэн 2019 оны ...сарын ...-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 2 сарын 18-ны өдрийн
..тоот тогтоолын Хавсралт №3

Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн анхааралд
Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 сарын 18-ны өдрийн
.. тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг: 2019 оны 4 сарын 27-ний өдрийн 9:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхимд хуралдана.

Компанийн оноосон нэр: Ард Даатгал ХК

Хурлын хэлэлцэх асуудал:

1. 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Бүртгэлийн өдөр: 2019 оны 3 сарын 15

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2019 оны 4 сарын 27-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар хаягаар ирж хурлын материалтай танилцах боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар Утас: 77200088, 88052739

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 2 сарын 18-ны өдрийн
..тоот тогтоолын Хавсралт №4

**2019 ОНЫ 4 САРЫН 27-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн анкет, танилцуулга;

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр Хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Ард Даатгал ХК
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж 2,
Хурал хуралдах өдөр, цаг	2019 оны 4 сарын 27-ны өдөр, 9:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхим
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2019 оны 2 сарын 18-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2019 оны 2 сарын 25-ны өдөр
Бүртгэлийн өдөр	2019 оны 3 сарын 15-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2019 оны 3 сарын 4-ний өдөр
Хүргүүлсэн огноо	2019 оны 3 сарын 4-ний өдөр
Хурлын даргын нэр	Ч.Ганхуяг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Тооллогын комиссын дарга: Г.Алтансүх Тооллогын комиссын гишүүд: Б.Мөнхзул, З.Төрболд
Баримт, бичгийн жагсаалт	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо

Хурал зохион байгуулах комиссын дарга

..... /...../

2019 оны 2 сарын 19-ний өдөр